

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/192/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: <a href="mailto:tsogbayara@audit.gov.mn">tsogbayara@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 51-261628 Цахим хаяг: <a href="mailto:Bujinlkhandj@audit.gov.mn">Bujinlkhandj@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/650  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН САНХҮҮ, АР ТАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА  
Т.МӨНХДОРЖ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн хандив, тусламжаар орсон нийт орлогоос 3,215,899.5 мянган төгрөгийг төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэлгүй ХААН банкны данснаас зарцуулсан;
2. Санхүүгийн тайланд хүлэмжийн 2,629,793.0 мянган төгрөгийн өглөгийн, сургалт, олон нийттэй харилцах төвийн барилга байгууламжийн урьдчилгаа санхүүжилтийн 1,259,999.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан;
3. Тайлант хугацаанд 8 хүлэмжийг суурилуулж, барихад байгууллагын төсвөөс 1,512,251.1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй, гэрээний дагуу 4 хүлэмжийг суурилуулж барих зардалд 525,750.4 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр нь шийдвэрлэгдээгүй;
4. Мөнгөн гүйлгээний тайланд зардлын ангиллыг нийт 2,393,813.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;

5. "Гамшгаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг, зөвлөмж мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах" нэг төрлийн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоогүй 83 хуулийн этгээдтэй нийт 1,275,820.9 мянган төгрөгийн ажил үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "ангилал", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор "Малчдад тусалъя" хандивын аянд 52 иргэн, 33 аж ахуйн нэгж, 119 төрийн байгууллага, 32 төрийн бус байгууллага болон гадаадын 3 байгууллага, иргэдээс нэмэлт санхүүжилтийн дансанд 19,116.0 мянган төгрөг, ХААН банкны дансанд 3,870,236.5 мянган төгрөг, нийт 3,882,564.5 мянган төгрөгийн мөнгөн хандив хүлээн авснаас Монгол Улсын Шадар Сайдын 2024 оны 25, 42, 43, 51, 114, Улсын Онцгой комиссын даргын 2024 оны 4, 5, 8, 11, 12 дугаар тушаалын дагуу өвөлжилт хаваржилт хүндэрсэн аймаг, сумдад дэмжлэг үзүүлэх, хаагдсан зам давааг нээх, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгахад ажилласан алба хаагчдын томилолт, ариутгал халдваргүйтгэлийн төлбөр болон үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор зөөврийн далан, хүн нэг бүрийн усны хувцас, цув, бээлий зэргийг худалдан авахад нийт 3,657,137.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллага нь Гамшгаас хамгаалах хууль, тогтоомж, түүнтэй холбоотой төрийн бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ.

Тайлант онд 146 албан хаагчдад тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид нийт 7,838,183.2 мянган төгрөгийг, аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчдад таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгохоор хуульчилсан бөгөөд 2024 онд 112 алба хаагчдад нийт 2,804,499.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

## Бусад асуудал

Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах, живсэн тээврийн хэрэгслийг илрүүлэх, байршлыг тогтоох, татан гаргах ажлыг 2021-2024 онуудад Онцгой байдлын ерөнхий газраас удирдан зохион байгуулж Зэвсэгт хүчний жанжин штаб, Шинжлэх ухаан, техникийн их сургууль, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн эрдэмтэд, зөвлөх инженер, судалгааны баг хамтран Хөвсгөл нуурт живсэн “Сүхбаатар” хөлөг онгоц болон бусад 11 автомашин, техник хэрэгслийг 33.4-171 метрийн гүнээс татан гаргаж, тэдгээрт агуулагдаж байсан 50 орчим тонн шатахуун, тос тосолгооны материал, аюултай хог хаягдлыг аюулгүй болгосон.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,590,546,928.45	48,399,867,866.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	8,470,608,947.74	5,143,122,354.71
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7,996,948,315.74	4,514,279,126.91
33500	Бусад авлага	473,660,632.00	628,843,227.80
33510	Байгууллагаас авах авлага	473,660,632.00	628,843,227.80
34	УРЬДЧИЛГАА	1,751,875,598.91	3,158,049,676.72
34600	Урьдчилж гарсан зардал	1,751,875,598.91	3,158,049,676.72
35	БАРАА МАТЕРИАЛ	35,368,062,381.80	11,472,365,834.77
351	Түүхий эд материал	4,391,526,340.83	6,701,449,255.00
35110	Тусгай зориулалтын материал	4,386,920,320.83	6,695,440,262.00
35130	Эм боох материал	4,606,020.00	6,008,993.00
35400	Хангамжийн материал	30,976,536,040.97	4,770,916,579.77
35410	Бичиг хэргийн материал	104,354,823.70	281,110,507.70
35420	Аж ахуйн материал	601,678,011.16	902,856,432.16
35430	Сэлбэг хэрэгсэл	1,281,811,103.66	1,293,621,103.66
35440	Түлш, шатах тослох материал	47,240,000.00	131,560,000.00
35450	Барилгын засварын материал	793,000.00	22,249,500.00
35460	Хүнсний материал	3,117,300.00	12,207,569.80
35470	Бусад хангамжийн материал	28,937,541,802.45	2,127,311,466.45
36	НӨӨЦИЙН БАРАА	-	28,626,330,000.00
36600	Бусад нөөц	-	28,626,330,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,659,947,121.16	6,580,532,326.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,659,947,121.16	6,580,532,326.99
39200	Биет хөрөнгө	4,198,091,756.73	5,318,290,777.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,641,475,605.19	3,641,606,205.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(689,460,621.80)	(823,299,070.40)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,677,354,160.13	5,069,784,330.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,578,928,212.90)	(3,007,124,081.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	581,546,132.66	541,364,505.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(440,070,973.24)	(125,797,510.74)
25213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,400,000.00	3,400,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,356,400.00	18,356,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,580,733.31)	-
39300	Биет бус хөрөнгө	461,855,364.43	1,262,241,549.60
39301	Программ хангамж	236,729,358.70	687,025,696.20
39302	Хуримтлагдсан элэгдэл	(95,072,914.27)	(148,322,666.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	320,198,920.00	723,538,520.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	50,250,494,049.61	54,980,400,193.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,768,625,060.75	2,641,007,570.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,768,625,060.75	2,641,007,570.00
412	Богино хугацаат зээлийн өглөг	103,702,796.95	-
4121	Төгрөг	103,702,796.95	-
41217	Санхүүгийн бусад байгууллага	103,702,796.95	-
413	Өглөг	2,664,922,263.80	2,641,007,570.00
4136	Бусад өглөг	2,664,922,263.80	2,641,007,570.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,464,922,263.80	2,441,007,570.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	200,000,000.00	200,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	47,481,868,988.86	52,339,392,623.19
51	Засгийн газрын хувь оролцоо	47,481,868,988.86	52,339,392,623.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470,087,565.96	470,087,565.96
51101	Өмч: - төрийн	470,087,565.96	470,087,565.96
51200	Хуримтлагдсан үр дүн	44,527,233,743.33	49,389,878,177.66

Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	44,527,233,743.33	44,532,354,543.33
51220	Тайлант үеийн үр дүн	-	4,857,523,634.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,484,547,679.57	2,479,426,879.57
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>50,250,494,049.61</b>	<b>54,980,400,193.19</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>81,959,207,289.96</b>	<b>130,639,698,172.17</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,845,241,117.57</b>	<b>7,611,501,745.74</b>
120	Нийтлэг татварын бус орлого	2,845,241,117.57	3,741,265,213.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,845,241,117.57	-
120009	Бусад орлого	-	375,519.31
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	1,832,060,689.42
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	1,908,829,005.00
122	Тусламжийн орлого	-	3,215,899,512.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	3,215,899,512.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>79,113,966,172.39</b>	<b>123,682,533,446.44</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	55,178,364,400.00	69,657,170,250.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	55,178,364,400.00	69,657,170,250.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,935,601,772.39	54,025,363,196.44
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	860,895,491.90	4,318,295,606.21
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	16,619,110,411.15	44,764,451,797.35
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,600,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,855,595,869.34	4,942,615,792.88
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>61,749,515,016.19</b>	<b>100,972,629,459.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>61,749,515,016.19</b>	<b>100,972,629,459.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>44,864,536,166.33</b>	<b>89,528,963,886.27</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,990,336,232.61	5,402,583,565.26
210101	Үндсэн цалин	1,703,062,300.00	2,521,221,665.00
210102	Нэмэгдэл	2,037,393,832.61	2,514,816,629.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	134,008,500.00	174,743,000.00
210104	Урамшуулал	115,871,600.00	191,802,271.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,126,708.70	107,042,777.48
210201	Тэтгэврийн даатгал	1,418,657.00	1,082,962.00
210202	Тэтгэмжийн даатгал	166,901.00	127,408.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	133,520.00	1,287,017.00
210204	Ажилгүйдлийн даатгал	33,381.00	25,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	79,374,249.70	104,520,290.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,303,149.96	174,363,182.23
210301	Гэрэл, цахилгаан	106,243,660.44	110,609,508.23
210302	Түлш, халаалт	36,886,164.90	36,074,400.81
210303	Цэвэр, бохир ус	7,540,421.33	9,629,848.32
210304	Байрны түрээс	5,632,903.29	18,049,424.87
2104	Хангамж, бараа материалын зардал	562,828,511.95	2,920,073,872.84
210401	Бичиг хэрэг	104,706,404.60	72,399,806.60
210402	Тээвэр, шатахуун	143,151,825.60	2,445,434,159.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,710,288.82	25,955,079.24

Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,673,000.00	4,543,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	288,586,992.93	369,235,528.00
210408	Бараа материал акталсны зардал		2,506,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	790,119,615.80	615,666,424.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,914,080.00	116,179,200.00
210604	Урсгал засвар	768,205,535.80	499,487,224.00
2107	Томилолт, зочны зардал	132,693,342.00	393,698,007.00
210702	Дотоод албан томилолт	132,693,342.00	393,698,007.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,117,587,711.00	23,339,181,827.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,672,168,656.59	18,495,473,448.86
210803	Даатгалын үйлчилгээ	4,351,623,330.80	4,545,488,236.91
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	36,845,176.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	90,470,387.09	253,375,915.34
210807	Газрын төлбөр	3,325,336.52	7,999,050.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,815,671,305.51	55,972,681,955.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,907,599,694.53	54,945,846,601.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	194,041,990.00	337,829,266.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	714,029,620.98	689,006,088.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,884,978,849.86	11,443,665,572.74
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	192,755,909.00	111,651,150.88
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	192,755,909.00	111,651,150.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,621,861,552.00	10,929,380,908.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,770,585,085.00	42,147,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,410,900.00	4,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,393,889,077.00	7,838,333,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	2,804,499,808.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	452,976,490.00	240,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	70,361,388.86	402,633,513.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,662,003.52	32,547,253.77
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21,699,385.34	370,086,260.09
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	20,209,692,273.77	29,667,068,713.16
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,842,835,553.49	24,809,545,078.83
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	124,083.34	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	2321437052.05	1190000
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	18521274418.1	24808355078.83
v	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(20,842,835,553.49)	(24,809,545,078.83)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(633,143,279.72)	4,857,523,634.33

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	83,577,041,007.39	134,925,881,274.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,215,899,512.00
122	Тусламжийн орлого	-	3,215,899,512.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	3,215,899,512.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83,577,041,007.39	131,709,981,762.18
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	55,178,364,400.00	69,657,170,250.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	55,178,364,400.00	69,657,170,250.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,398,676,607.39	62,052,811,512.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	860,895,491.90	4,318,295,606.21
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,619,110,411.15	44,764,451,797.35
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,600,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,318,670,704.34	12,970,064,108.62
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,809,063,537.39	125,734,602,669.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,809,063,537.39	125,734,602,669.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,927,136,371.79	109,776,657,969.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,985,749,698.07	5,402,357,470.11
210101	Үндсэн цалин	1,703,062,300.00	2,521,221,665.00
210102	Нэмэгдэл	2,032,807,298.07	2,514,590,534.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	134,008,500.00	174,743,000.00
210104	Урамшуулал	115,871,600.00	191,802,271.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,548,100.00	108,510,720.43
210201	Тэтгэврийн даатгал	205,500.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	24,200.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,300.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	4,800.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	79,294,300.00	108,510,720.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,971,427.16	188,659,012.90
210301	Гэрэл, цахилгаан	106,243,660.44	110,609,508.23
210302	Түлш, халаалт	36,886,164.90	36,074,400.81
210303	Цэвэр, бохир ус	7,540,421.33	9,629,848.32
210304	Байрны түрээс	33,301,180.49	32,345,255.54
2104	Хангамж, бараа материалын зардал	3,636,768,309.62	4,220,055,074.64
210401	Бичиг хэрэг	38,268,122.00	58,089,294.60
210402	Тээвэр, шатахуун	3,362,088,853.80	3,838,262,821.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,710,288.82	46,021,417.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,673,000.00	4,543,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	210,028,045.00	273,138,541.00
2105	Нормативд зардал	2,863,474,345.00	7,596,296,531.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,228,570.00	776,848,292.16
210502	Хоол, хүнс	116,218,974.00	406,762,754.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,742,026,801.00	6,412,685,485.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	970,367,894.96	2,728,939,425.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	159,377,009.16	2,047,110,711.97
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,433,600.00	27,420,000.00
210604	Урсгал засвар	805,557,285.80	654,408,714.00
2107	Томиллолт, зочны зардал	130,769,742.00	394,363,183.00

Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210702	Дотоод албан томилолт	130,769,742.00	394,363,183.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,680,855,590.63	28,527,737,335.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,405,287,835.59	20,012,499,054.86
210803	Даатгалын үйлчилгээ	3,172,239,031.43	5,948,692,314.72
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	37,200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,003,387.09	2,521,346,915.34
210807	Газрын төлбөр	3,325,336.52	7,999,050.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,395,631,264.35	60,609,739,215.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,189,136,474.35	60,308,828,093.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	206,494,790.00	300,911,122.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,881,927,165.60	15,957,944,699.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	192,755,909.00	111,651,150.88
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	192,755,909.00	111,651,150.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,621,861,552.00	10,929,380,908.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,770,585,085.00	42,297,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,410,900.00	4,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,393,889,077.00	7,838,183,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	2,804,499,808.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	452,976,490.00	240,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,067,309,704.60	4,916,912,640.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,662,003.52	32,547,253.77
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,018,647,701.08	4,884,365,387.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,767,977,470.00	9,191,278,605.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,767,977,470.00	9,191,278,605.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,767,977,470.00	9,191,278,605.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,767,977,470.00	9,191,278,605.00
223001	Бусад хөрөнгө	8,500,000,000.00	8,500,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	267,977,470.00	691,278,605.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,767,977,470.00)	(9,191,278,605.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,087,565.96	2,484,650,262.67	45,160,377,023.05	48,115,114,851.68
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470,087,565.96	2,484,650,262.67	45,160,377,023.05	48,115,114,851.68
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(633,143,279.72)	(633,143,279.72)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,087,565.96	2,484,547,679.57	44,527,233,743.33	47,481,868,988.86
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,120,800.00	5,120,800.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470,087,565.96	2,484,547,679.57	44,532,354,543.33	47,486,989,788.86
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(5,120,800.00)	-	(5,120,800.00)
12	Тайлант үеийн үр дүн	-	-	4,857,523,634.33	4,857,523,634.33
13	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	470,087,565.96	2,479,426,879.57	49,389,878,177.66	52,339,392,623.19

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,657,284,900.00	69,254,536,736.14	32,661,903.77	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,157,284,900.00	61,124,622,996.23	32,661,903.77	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,115,137,500.00	50,083,590,937.35	31,546,562.65	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,402,584,700.00	5,402,357,470.11	227,229.89	100.0
210101	Үндсэн цалин	2,483,718,200.00	2,521,221,665.00	(37,503,465.00)	101.5
210102	Нэмэгдэл	2,538,814,200.00	2,514,590,534.11	24,223,665.89	99.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	178,335,000.00	174,743,000.00	3,592,000.00	98.0
210104	Урамшуулал	201,717,300.00	191,802,271.00	9,915,029.00	95.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,074,200.00	108,510,720.43	3,563,479.57	96.8
210205	Эрүүл мэндийн даатгал	112,074,200.00	108,510,720.43	3,563,479.57	96.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,404,200.00	188,659,012.90	2,745,187.10	98.6
210301	Гэрэл, цахилгаан	113,199,000.00	110,609,508.23	2,589,491.77	97.7
210302	Түлш, халаалт	36,076,400.00	36,074,400.81	1,999.19	100.0
210303	Цэвэр, бохир ус	9,748,100.00	9,629,848.32	118,251.68	98.8
210304	Байрны түрээс	32,380,700.00	32,345,255.54	35,444.46	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	4,184,360,400.00	4,183,998,974.64	361,425.36	100.0
210401	Бичиг хэрэг	58,089,700.00	58,089,294.60	405.40	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,801,763,000.00	3,801,762,821.80	178.20	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,178,100.00	46,021,417.24	156,682.76	99.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,545,300.00	4,543,000.00	2,300.00	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	273,784,300.00	273,582,441.00	201,859.00	99.9
2105	Нормативд зардал	7,596,296,800.00	7,596,296,531.86	268.14	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	776,848,600.00	776,848,292.16	307.84	100.0
210502	Хоол, хүнс	406,759,900.00	406,762,754.70	(2,854.70)	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,412,688,300.00	6,412,685,485.00	2,815.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,836,063,600.00	2,835,880,630.97	182,969.03	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,110,927,900.00	2,110,770,916.97	156,983.03	100.0

Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	27,435,700.00	27,420,000.00	15,700.00	99.9
210604	Урсгал засвар	697,700,000.00	697,689,714.00	10,286.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	394,631,500.00	394,363,183.00	268,317.00	99.9
210702	Дотоод албан томилолт	394,631,500.00	394,363,183.00	268,317.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,016,480,600.00	28,992,577,335.44	23,903,264.56	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,039,435,200.00	20,017,339,054.86	22,096,145.14	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	93,700.00	-	93,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	5,949,502,800.00	5,948,692,314.72	810,485.28	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,200,000.00	37,200,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,981,371,900.00	2,981,346,915.34	24,984.66	100.0
210807	Газрын төлбөр	8,799,200.00	7,999,050.52	800,149.48	90.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	77,800.00	-	77,800.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	381241500.00	380947078.00	294,422.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,217,300.00	80,035,956.00	181,344.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	301,024,200.00	300,911,122.00	113,078.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11042147400.00	11041032058.88	1,115,341.12	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	112,510,000.00	111,651,150.88	858,849.12	99.2
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	112,510,000.00	111,651,150.88	858,849.12	99.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,929,637,400.00	10,929,380,908.00	256,492.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	42,315,000.00	42,297,900.00	17,100.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,400,000.00	100,000.00	97.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,838,183,200.00	7,838,183,200.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,804,639,200.00	2,804,499,808.00	139,392.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000,000.00	240,000,000.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,500,000,000.00	8,500,000,000.00	-	100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	8,500,000,000.00	8,500,000,000.00	-	100.0
223001	Бусад хөрөнгө	8,500,000,000.00	8,500,000,000.00	-	100.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	69,657,284,900.00	69,624,622,996.23	32,661,903.77	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,657,284,900.00	69,624,622,996.23	32,661,903.77	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	69,657,284,900.00	69,624,622,996.23	32,661,903.77	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	105	105	-	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	103	103	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	62,052,811,512.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	62,052,811,512.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	57,168,446,125.18
2104	Хангамж, бараа материалын зардал	-	36,500,000.00
210401	Бичиг хэрэг	-	
210402	Тээвэр, шатахуун	-	36,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	60,820,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	60,820,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	57,071,126,125.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	57,071,126,125.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	4,884,365,387.00
2133	Бусад урсгал шилжүүлэг	-	4,884,365,387.00
213305	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,884,365,387.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	62,052,811,512.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	62,052,811,512.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	4,972,632,626.22
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	44,764,451,797.35
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,315,727,088.61

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 104,072.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 39,546.0 сая төгрөгийн алдааг залруулж, 7.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 21,811.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлж, 42,707.3 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

3.1 Аудитаар нийт 39,546.0 сая төгрөгийн алдаа илрүүлснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Арилжааны банканд хуримтлуулан бүртгэсэн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хандив тусламжийн 3,870,236.5 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн "Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж"-ийн орлогоор бүртгэж тайлагнасан.	1	3,870,236.5	-	-	1	3,870,236.5	1	3,870,236.5	-	-	-	-
Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг 1,665,896.9 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 1,276,443.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	2,942,340.3	-	-	1	2,942,340.3	1	2,942,340.3	-	-	-	-
Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан 18,882,000.0 мянган төгрөгийн 12 ширхэг хүлэмж, 911,050.0 мянган төгрөгийн хөвдөн хөрс, бордоо, бортого, мод, Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон 123-р ангид баригдсан 8,800,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий нөхөн сэргээх нэгжийн барилга байгууламжийг бараа материалын тайланд нярвын үлдэгдлээр бүртгэсэн	1	28,626,330.0			1	28,626,330.0	1	28,626,330.0	-	-	-	-
Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн Зудын гамшгийн хариу арга хэмжээний төсөл, болон НҮБ-ын Хүүхдийн сангаас өгсөн 4,107,103.7 мянган төгрөгийн хандивын орлогыг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	1	4,107,103.7	-	-	1	4,107,103.7	1	4,107,103.7	-	-	-	-

Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

хүрээнд бий болсон нэмэлт орлогоор тайлагнасан.													
Дүн	4	39,546,010.5	-	-	4	39,546,010.5	4	39,546,010.5	-	-	-	-	

3.2 Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 25,748.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 7.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 20,535.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлж, 5,205.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Тайлант онд нэр бүхий 17 ажилтанд нийт 7,468.7 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.	1	7,468.7	1	7,468.7	-	-	-	-	-	-
Нэгдсэн үндэстний байгууллага /НҮБ/-ын Хүүхдийн сангийн төсвийн эх үүсвэрээр Улаанбаатар хотод зохион байгуулсан “Мэргэшил ба мэргэжил”, “Гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэдэвт сургалтад Онцгой байдлын ерөнхий газрын 67 албан хаагчдад нийт 7,580.4 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг анхан шатны баримтгүйгээр олгожээ.	1	7,580.4	-	-	1	7,580.4	-	-	-	-
Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн хандив, тусламжийн орлого 3,870,236.5 мянган төгрөгөөс 3,215,899.5 мянган төгрөгийг Онцгой байдлын ерөнхий газрын Төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлээгүй ХААН банкны данснаас шууд зарцуулсан.	1	3,215,899.5	-	-	1	3,215,899.5	-	-	-	-
Мөнгөн гүйлгээний тайланд зардлын ангиллыг нийт 2,393,813.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Тухайлбал: бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 2,109,901.3 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардал, дотоод томилолтын зардлаас 113,280.9 мянган төгрөгийн гадаад томилолт, Багаж техник хэрэгслийн зардлаас 77,115.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 93,516.0 мянган төгрөгийн томилолт болон шатахууны зардал гаргаж, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна.	1	2,393,813.9	-	-	-	-	1	2,393,813.9	-	-
1. Тайлант хугацаанд Онцгой байдлын ерөнхий газрын 20 жилийн ойн арга хэмжээнд төсвөөс 396,709.2 мянган төгрөгийг баярын хурал, хүндэтгэлийн арга хэмжээ, баримтат кино, урлагийн	1	575,357.7	-	-	-	-	1	575,357.7	-	-

Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

наадам, ном хэвлүүлэх гэх зэрэг зардалд зарцуулсан; 2. Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй уралдаан тэмцээн зохион байгуулж хоол, ус, шагнал, цом, өргөмжлөлийн үнэд 178,648.5 мянган төгрөгийг зарцуулсан;										
Арилжааны банканд Онцгой байдлын ерөнхий газрын ашиглагддаггүй 3 данс байршуулсан.	1	-	-	-	-	-	1	-	-	-
Санхүүгийн тайланд 2021 онд үүссэн 15,150.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	15,150.0	-	-	-	-	1	15150.0	-	-
1. "Тэрбум мод" Үндэсний хөдөлгөөний хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-аас хэрэгжүүлж байгаа "Сая тонн-Сая мод" хөтөлбөрийн хүрээнд үндэсний мод үржүүлгийн газруудыг байгуулах, мод бут тарьж арчлан ургуулах ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газар нь "Эрдэнэс таван толгой" ХК-тай 2022 онд 10 жилийн хугацаатай гэрээ байгуулан тус онд 27,500,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан. Тус гэрээний 3.3-т гэрээг хэрэгжүүлсний үр дүнд бий болсон эд хөрөнгө нь "ЭТТ" ХК-ийн өмч болох талаар заасан хэдий ч талууд 2022 онд хийсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнээгүй, хийгдсэн хөрөнгийг хүлээлцээгүй. 2. Онцгой байдлын ерөнхий газар нь бэлтгэн нийлүүлэгчидтэй 16 ажлын хүрээнд нийт 34,956,453.6 мянган төгрөгийн гэрээ байгуулснаас 7,526,792.5 мянган төгрөгийн гэрээний үлдэгдэлтэй, нэмэлт санхүүжилтгүйн улмаас 4 гэрээт ажлууд хийгдэхгүй зогссон байна. Санхүүгийн тайланд хүлэмжийн 2,629,793.3 мянган төгрөгийн өглөг, сургалт, олон нийттэй харилцах төвийн барилга байгууламжийн урьдчилгаа санхүүжилт 1,259,999.6 мянган төгрөгийг авлагаар тайлагнасан нь он дамнасан байна.	1	7,526,792.5	-	-	-	7,526,792.5	-	-	-	
Тайлант хугацаанд 8 хүлэмжийг суурилуулж, барихад байгууллагын төсвөөс 1,512,251.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй, цаашид гэрээний дагуу 4 хүлэмжийг суурилуулж барих зардалд 525,750.4 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй байна.		2,038,001.4	-	-	-	2,038,001.4	-	-	-	-
"Гамшгаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг, зөвлөмж мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах" гэрээний хэрэгжилт хангалтгүй, 4 гэрээний хугацаа дууссан байхад хэрэгжилтийг хангуулаагүй, үлдэгдэл төлбөр болох 3,295.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй.	1	3,295.0	-	-	-	-	1	3,295.0	-	-
Онцгой байдлын ерөнхий газрын бараа материалд бүртгэлтэй хөрөнгийн үлдэгдлийг шалгаж үзэхэд харьяа байгууллагад	1	3,730,552.2	-	-	1	3,730,552.2	-	-	-	-

Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

хүлээлгэн өгсөн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлээс хасаагүй зөрчил илэрсэн. Тухайлбал: 1. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа ар талын 115 дугаар ангид хүлээлгэн өгсөн 2,470,270.0 мянган 10 нэр төрлийн 656 ширхэг хөрөнгө, хөрөнгө хүлээлцсэн актгүй, агуулахын хүртээмжгүйн улмаас тус ангийн агуулахад байршуулсан 785,776.3 мянган төгрөгийн 8 нэр төрлийн 24,755 ширхэг хөрөнгө нь эд хариуцагчийн үлдэгдэлд бүртгэлтэй; 2. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа ар талын 115 дугаар ангид байршдаг Швейцарь хөгжлийн агентлаг сургалтын өрөөнд 155,367.5 мянган төгрөгийн 33 нэр төрлийн 357 ширхэг хөрөнгө байрладаг боловч эд хариуцагчид хүлээлгэн өгөөгүй; 3. Нийслэлийн Онцгой байдлын газарт 178,359.0 мянган төгрөгийн 3 хөрөнгийг хүлээлгэн өгсөн боловч бүртгэлээс хасаагүй; 4. Харьяа нэгжүүдэд болон албан хаагч нартаа өгсөн 323,061.4 мянган төгрөгийн 11 нэр төрлийн 536 ширхэг хөрөнгийг хүлээлгэн өгсөн боловч бүртгэлээс хасаагүй;										
Бараа материалын ангилалд үндсэн хөрөнгийн шинжтэй 3,477,035.6 мянган төгрөгийн үнэ бүхий 90 нэр төрлийн 8293 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	1	3,477,035.6	-	-	1	3,477,035.6	-	-	-	-
Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр Монгол цэргийн нэгдсэн холбоо ТББ байгууллагад 10,276.5 мянган төгрөгийн 3 ширхэг компьютерыг, Дотоод хэргийн их сургуульд 8,641.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг компьютер, 2 ширхэг хэвлэгчийг тус тус үнэ төлбөргүй шилжүүлсэн.	1	18,917.5	-	-	1	18,917.5	-	-	-	-
Тайланд онд анхан шатны баримтгүй нийт 520,606.7 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан. Үүнд: Шатахууны зарлагын баримтгүй 125,748.4 мянган төгрөг, жолоочийн замын хуудасгүй 74,539.9 мянган төгрөг; жолоочийн шатахууны зарцуулалтын тооцоог бодолгүй 320,321.4 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан.	1	520,609.8	-	-	1	520,609.8	-	-	-	-
Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн аймаг, сумдад үүссэн цаг үеийн ажилд зарцуулсан 2,217,632.0 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан.	1	2,217,632.1	-	-	-	-	1	2,217,632.1	-	-
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 13,394.6 мянган төгрөгийн барилга, байгууламж, 1,778,237.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 14,000.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 1,805,632.1 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 53 нэр төрлийн 268 ширхэг хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>25,748,106.3</b>	<b>1</b>	<b>7,468.7</b>	<b>7</b>	<b>20,535,388.9</b>	<b>7</b>	<b>5,205,248.7</b>		

--	--	--	--	--	--	--	--	--	--

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.3. Нийцлийн аудиттай холбоотой нийт 38,777.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1,275.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж, 37,502.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2,140,395.6 мянган төгрөгийн орлогын 6 гүйлгээг, 5,402,027.9 мянган төгрөгийн зарлагын 81 гүйлгээг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой нийт 9,649,204.0 мянган төгрөгийн 328 тушаал, шийдвэрийг хугацаа хоцруулж мэдээлсэн.	1	17,191,627.5	-	-	-	-	1	17,191,627.5
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>17,191,627.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>17,191,627.5</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй, төлөвлөгөөнд тусгасан дүнгээс 20,310,505.9 мянган төгрөгөөр илүү бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан.	1	20,310,505.9					1	20,310,505.9
"Гамшгаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг, зөвлөмж мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах" нэг төрлийн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоогүй 83 хуулийн этгээдтэй нийт 1,275,820.9 мянган төгрөгийн ажил үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн.	1	1,275,820.9			1	1,275,820.9		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>21,586,326.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,275,820.9</b>	<b>1</b>	<b>20,310,505.9</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>3</b>	<b>38,777,954.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,275,820.9</b>	<b>2</b>	<b>37,502,133.4</b>